Нүүр амны гажгийн тархалт

Б.Золзаяа[1], Ж.Цолмон[2], Г.Ганжаргал[1], Н.Цэнгэлсайхан[3]
[1]АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль
[2] Монтаймлайн төсөл
[3]АШУҮИС-ийн Эрдмийн сургууль
zolzaya.bo@mnums.edu.mn

Түлхүүр үг
Энглийн ангилал; шүд хооронд зай, диастем

Товч утга
Улаанбаатар хотод хийгдсэн судалгаануудын дүнгээс харахад 1983 онд нүүр амны гажгийн тархалт 64.6%, 2004 онд 87%, 2006 онд 79.5%, 2011 онд 85.9% байгаа нь нүүр амны гажгийн тархалт нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Улаанбаатар хотын хүн амын дундах нүүр амны гажгийн тархалтыг судлах зорилгыг дэвшүүлэв. Амны хөндийн үзлэгээр нүүр амны гажгийг Энглийн ангилал дагуу тэмдэглэн, шүдний байрлалын гажгийг үүдэн бүлгийн шүднүүдийн хоорондын харьцааг шугамаар хэмжин тодорхойллоо. Статистик боловсруулалтыг SPSS 21 программ дээр гүйцэтгэн хийлээ. Судалгаанд оролцогчдын 13-18 насны бүлэгт нүүр амны гажиг 91,8%, 19-29 насанд 94,1% хамгийн өндөр байлаа. Судалгаанд оролцогчдын 52.8% нь Энглийн С1 ангилалын гажиг, 42.1% Энглийн С2 ангилалын гажиг, 5.1% нь Энглийн С3 ангиллын гажигтай байсан бол шүдний байрлалын гажиг 85.1% хувьтай байлаа. Нүүр амны гажгийн тархалтыг тогтоосноор гажгийг эрт үед нь илрүүлэх, оношилгоог нарийвчлан хийх, эмчилгээний төлөвлөгөөг сайжруулах улмаар гажиг үүсгэх эрсдэлт хүчин зүйлсийг танин мэдэж нүүр амны гажиг үүсэхээс урьдчилан сэргийлэх нь манай орны нүүр ам судлалын салбар дахь нэн чухал тулгамдсан асуудлуудын нэг болж байна.

Үндэслэл

Хоншоор, эрүүний шүднүүд хоорондоо хэвийн бус харьцаатай харьцахыг нүүр амны гажиг (Өвчний олон улсын ангиллын (ӨОУА) М.26) гэнэ. Нүүр амны гажгийг шалтгаанаар нь ясны гаралтай, зөөлөн эдийн гаралтай, шүдний гаралтай гэж ангилдаг. Улаанбаатар хотод хийгдсэн судалгаануудын дүнгээс харахад 1983 онд шүдний гажгийн тархалт 64.6%, 2004 онд 87%, 2006 онд 79.5%, 2011 онд 85.9% байгаа нь шүдний гажгийн тархалт нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд шинэчлэн тогтоогдоогүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго, зорилт

Улаанбаатар хотын хүн амын дундах нүүр амны гажгийн тархалтыг судлах

1. Улаанбаатар хотын 13-50 настай хүн амын дундах нүүр амны гажгийн тархалтыг судлах
2. Улаанбаатар хотын 13-50 настай хүн амын дундах нүүр амны гажгийн тархалтыг насны бүлэг болон хүйсээр судлах
3. Улаанбаатар хотын 13-50 настай хүн амын дундах нүүр амны гажгийн тархалтыг төрөл ангиллаар судлах

Арга аргачлал

Таймлайн төсөл нь нүүр ам судлал, тархи судлал, мэдрэл судлал, сэтгэцийн эмгэг судлал, дотоод шүүрэл судлал, чих хамар хоолой судлал, өрхийн анагаах ухаан судлал, эмэгтэйчүүдийн өвчин судлал, дотрын өвчин судлалын салбар дундын кохорт "Монгол хүн амын дундах нүүр амны гажиг, нойрны эмгэгийн тархалт, тэдгээрийн эмнэлзүйн хэв шинжийн онцлог, хоорондын хамаарал, эмчилгээний зарим асуудалд" судалгаа бөгөөд 2020-2025 оны хооронд 3 үе шаттайгаар, Монгол улсын газарзүйн бүсчлэлийн дагуу 4 бүсийн 8 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг хамрагдана . Судалгааг агшингийн судалгааны загварыг ашиглан 2020 оны 5 сараас 2020 оны 7 сарын хооронд Таймлайн төслийн хүрээнд Улаанбаатар хотод цуглуулсан датан дээр анализ хийсэн. НАГ-ийг илрүүлэхэд Энглийн эмнэлзүйн ангилал, эрүү, хоншоорын харьцаа, хоншоор, эрүүний үүдэн шүдний харьцааг тодорхойлох амны хөндийн үзлэгийг НАГ-ийн байдлыг тодорхойлох аргуудыг ашиглан хийж үзлэгийн картанд тэмдэглэгээ хийсэн. Статистик боловсруулалтыг SPSS 21 программ дээр гүйцэтгэж, утгуудыг тодорхойлж

магадлалын түвшин p>0.05 үед тухайн хоёр үзүүлэлтийн хооронд статистик үнэн магадлалтай ялгаа байна гэж тооцсон.


Үр дүн

Судалгаанд нийт хүн 670 хамрагдсан. Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл: 13-18 насны 49 (НАГ- 91.8%), 19-29 насны 85 (НАГ-94.1%), 30-39 насны 92 (НАГ-85.9%), 40-49 насны 128 (НАГ-68%) тус тус байсан бол нийт оролцогчдын 103 нь эрэгтэй (НАГ-74.8%), 407 нь эмэгтэй (НАГ-66.8%) байсан. Судалгаанд оролцогчдын 169 буюу 33.1% нь сарын дундаж орлого 500.000 төгрөгөөс доош байв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

No. (%)	Эрүүл	Гажигтай	P утга
	No. (%)		
Нийт	163 (32.0)	347 (68.0)	
Нас_бүлэг			
13-18	4 (8.2)	45 (91.8)	0.0001
19-29	5 (5.9)	80 (94.1)	
30-39	13 (14.1)	79 (85.9)	
40-49	41 (32.0)	87 (68.0)	
50 дээш	100 (64.1)	56 (35.9)	
Хүйс			
Эр	26 (25.2)	77 (74.8)	0.102
Эм	137 (33.7)	270 (66.3)	
Орлого			
500 доош	83 (49.1)	86 (50.9)	0.0001
500-1 сая	35 (28.7)	87 (71.3)	
1-1,5 сая	7 (15.9)	37 (84.1)	
1,5-2 сая	1 (8.3)	11 (91.7)	
2 сая дээш	0 (0.0)	4 (100.0)	
Орлогогүй	37 (23.3)	122 (76.7)	
Ажлын_нөхцөл			
Ердийн	92 (28.4)	232 (71.6)	0.027
Хүнд	4 (23.5)	13 (76.5)	
Хортой	1 (14.3)	6 (85.7)	
Бусад	66 (40.7)	96 (59.3)	
Боловсрол			
Боловсролгүй	6 (14.3)	36 (85.7)	0.0001
Дунд	128 (41.7)	179 (58.3)	
дээд	29 (18.0)	132 (82.0)	
Гэрлэлт			
Гэрлээгүй	13 (11.2)	103 (88.8)	0.0001
гэрлэсэн	119 (34.6)	225 (65.4)	
Салсан/Бэлэвсэн	31 (62.0)	19 (38.0)	
Сууц			
Орон сууц	58 (27.4)	154 (72.6)	0.170
Гэр/Байшин	103 (35.3)	189 (64.7)	
Нийтийн	2 (33.3)	4 (66.7)	

Энглийн ангилалын дагуу нүүр амны гажгуудыг тархалтыг үнэлэхэд Энглийн С1 зуулт 52.8%, Энглийн С2 зуулт 42.1%, Энглийн С3 зуулт 5.1% байлаа (диаграм 1). Энглийн С1 ангилалд шүдний байрлалын гажгууд ихээр тохиолдох бөгөөд шүд хооронд зайтай байх, шүдний бөөгнөрөл хамгийн ихээр тохиолдлоо.



Зураг 1. Нүүр амны гажгийн тархалт төрлөөр

Дүгнэлт

Нүүр амны гажиг 94.1% байгаа нь тархалт маш ихэссэн бөгөөд гажгийг эрт үед нь илрүүлэх, оношилгоог нарийвчлан хийх, эмчилгээний төлөвлөгөөг сайжруулах улмаар гажиг үүсгэх эрсдэлт хүчин зүйлсийг танин мэдэж нүүр амны гажиг үүсэхээс урьдчилан сэргийлэх нь манай орны нүүр ам судлалын салбар дахь нэн чухал тулгамдсан асуудлуудын нэг болж байна.

Ном зүй

1. *Maged Sultan Alhammadi, Esam Halboub, Mona Salah Fayed. Global Distribution of Malocclusion Traits: A Systematic Review. Dental Press J Orthod. Nov-Dec 2018;23(6):40.e1-40.e10.*
2. *Thilander B, Pena L, Infante C, Parada SS, de Mayorga C. Prevalence of malocclusion and orthodontic treatment need in children and adolescents in Bogota, Colombia. An epidemiological study related to different stages of dental development: European journal of orthodontics. 2001;23(2):153–168*
3. *Thilander B, Myrberg N. The prevalence of malocclusion in Swedish schoolchildren. European Journal of Oral Sciences. 1973;81(1):12-20.*
4. *Silva RG, Kang DS. Prevalence of malocclusion among Latino adolescents. American Journal of Orthodontics and Dentofacial Orthopedics. 2001;119(3):313-315.*
5. *Цолмон Х. Морфологично характеристка на нормально и патологично постоянно сызьбие у монголситка ученици. АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Софиа, Болгар;1983.*
6. *Одончимэг Д. Байнгын дээд соёоны буруу ургалтын оношлогоо, хам эмчилгээний арга. АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар, Анагаах Ухааны Их Сургууль; 2004.*
7. *Пүрэвжав Н ЖП, Соёлгэрэл Г,Долгоржав Г, Дэлгэрцэцэг Д, Цэнгэлмаа С , нар. Монгол хүүхдийн дунд зонхилон тохиолдож буй нүүр амны өвчлөлийг тодорхойлох судалгаа. ЭМЯ. 2006.*
8. *Ангараг А. Улаанбаатар хотын 11 насны хүүхдүүдийн шүд, эрүү нүүрний гажгийн тархалтыг судалсан дүн. АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: 2011.*
9. *Цолмон Ж. Зөв төрхтэй Монгол эмэгтэйн хажуугийн телерентген зургийн үзүүлэлт. АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: 2011.*
10. *Downs WB. Analysis of the dentofacial profile. The Angle Orthodontist. 1956;26(4):191-212.*
11. *Rinchuse DJ, Rinchuse DJ. Ambiguities of Angle's classification. The Angle Orthodontist. 1989;59(4):295-298.*
12. *Roth RH. Functional Occlusion for the orthodontist (3). JCO. 1981;15(3):174-199.*

Prevalence of malocclusion

Zolzaya.B[1], Tsolmon.J[2], Ganjargal.G[1] Tsengelsaikhan.N[3]
[1]School of Dentistry, MNUMS
[2] Montimeline Project
[3]Graduate school, MNUMS
zolzaya.bo@mnums.edu.mn

ABSTRACT

The purpose of our population-based cross-sectional study was to assess the prevalence of malocclusion in Ulaanbaatar. **Methods:** The study was conducted between May and July, 2020, in Ulaanbaatar, Mongolia. Clinical examinations were carried out by trained orthodontist. Malocclusion recorded according to Angle Classification. **Results:** The study consists of 670 participants aged between 13 and 65 years (mean age=39.6±14.8), majority were females. The prevalence of malocclusion was most high 94.1% in age group 19-29. **Conclusion:** These results suggest that prevalence of malocclusion increasing. Participants with young age had most high prevalence.